



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 12 сарын 15 өдөр

Дугаар А/С/52

Арвайхээр

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1-ийн "г", Статистикийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 2 дахь заалт, Засгийн газрын "Тооллогын товыг өөрчлөн тогтоох тухай" 2003 оны 224, 2020 оны 208 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн нутаг дэвсгэрт байгаа мал, тэжээвэр амьтан, хашаа, худгийн тооллогыг 2020 оны 12 дугаар сард багтаан зохион байгуулсугай.


2.Мал, тэжээвэр амьтан, хашаа, худгийн 2020 оны тооллогыг аймгийн хэмжээнд удирдан зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, гадны аймаг, суманд отроор өвөлжиж буй өрхийн малыг тоолоход зориулж сумдад үзүүлэх шатахууны дэмжлэгийн хуваарийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Мал, тэжээвэр амьтан, хашаа, худгийн тооллогын бэлтгэл ажлыг хангах, хяналтын тооллого хийх, тооллогын дүнг нэгтгэх, үйл ажиллагааны зардалд 3.000.000 (гурван сая) төгрөг, сумдад гадны аймаг, суманд отроор өвөлжиж буй өрхийн малыг тоолох шатахууны дэмжлэгт 5.600.000 (таван сая зургаан зуун мянга) төгрөг нийт 8.600.000 (найман сая зургаан зуун мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Ганболд)-д зөвшөөрсүгэй.

4.Мал, тэжээвэр амьтан, хашаа, худгийн тооллого явуулах ажлын хэсгийг сумдад байгуулж, тооллогыг чанартай явуулахад чиглэсэн бэлтгэл, зохион байгуулалтын ажлыг сум, багийн түвшинд хангуулах, тооллогын ажилтнуудыг сургах, тооллогын комисст ажиллахаар томилогдсон хүмүүсийн халдвар хамгааллын дэглэмийг сахин ажиллах хариуцлагыг өндөржүүлж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах, тооллогын дүнг мэдээллийн санд шивж оруулах ажлыг удирдан зохион байгуулах, тооллого явуулахтай холбогдон гарах шууд зардлыг санхүүжүүлэхийг сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

5.Тооллогын бэлтгэл, зохион байгуулалтын ажлыг аймаг, сумын түвшинд хангаж, тооллогыг тогтоосон хугацаанд нь заавар, журмын дагуу чанартай явуулж, дүнг мэдээлэхийг ажлын хэсэг ахлагч (И.Доржсүрэн)-д даалгасугай.


ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011101259

Аймгийн Засаг даргын 2020 оны 12
дугаар сарын 15 ны өдрийн 17509 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт



МАЛ ТООЛЛОГЫН АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: И.Доржсүрэн – Аймгийн Засаг даргын орлогч

Гишүүд: О.Түмэнжаргал – Аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн
хэлтсийн дарга

С.Цэдэнбалжир – Аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж
ахуйн газрын дарга

Б.Цэнгэл - Аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн
газрын Мал аж ахуйн албаны дарга

А.Нямдаваа – Аймгийн мал эмнэлгийн албаны дарга

Н.Дулмаа – Аймгийн Засаг даргын тамгын газрын Хөрөнгө оруулалт,
хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга – Э.Лхамсүрэн- Аймгийн Засаг даргын дэргэдэх
Статистикийн хэлтсийн мэргэжилтэн

-оОо-

Аймгийн Засаг даргын 2020 оны 12
дугаар сарын 12 ны өдрийн 7/39 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт

ГАДНЫ АЙМАГТ ОТОРЛОЖ БАЙГАА МАЛЧИН ӨРХИЙГ МАЛ ТООЛЛОГОД
ХАМРУУЛАХАД ЗОРИУЛЖ СУМДАД ҮЗҮҮЛЭХ ШАТАХУУНЫ ДЭМЖЛЭГ

Д/д	Сумын нэр	Нийт малчин өрхийн тоо	Гадны аймагт оторлож байгаа малчин өрхийн тоо	Сумдад үзүүлэх шатахууны дэмжлэг /мян.төг/
1	Баян-Өндөр	837	249	500.0
2	Бүрд	628	71	200.0
3	Баянгол	824	305	600.0
4	Гучин-Ус	406	288	600.0
5	Есөнзүйл	718	108	300.0
6	Өлзийт	613	145	400.0
7	Зүүнбаян-Улаан	1104	40	200.0
8	Богд	1219	382	800.0
9	Сант	713	215	400.0
10	Төгрөг	568	261	500.0
11	Хужирт	1172	289	600.0
12	Хархорин	1148	72	200.0
13	Арвайхээр	724	103	300.0
Нийт		10674	2528	5.600.0